СҮХБААТАР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
*Statistics division of Sukhbaatar district*

# СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

# ИНФОГРАФИК

## 2022 I-VI



ТӨЛЛОГО ХӨДӨӨ АЖ АХУЙ 2022

НИЙСЛЭЛД 6.17-6.30 ХҮРТЭЛ

## ХҮН АМ

2022 оны эхний 6 сард Сүхбаатар дүүрэгт 1078 хүүхэд шинээр мэндэлж, 1000 хүнд ногдох төрөлт 7.4 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1.4 нэгжээр өсжээ.

### 1000 ХҮНД НОГДОХ

Төрөлт 7.4

Нас баралт 2.8

Ердийн цэвэр өсөлт 4.6

Оны эхний 6 сарын байдлаар нас баралт 400 бүртгэдэж, 2021 оны мөн үеэс 7-гоор (1.8%), өмнөх сараас 70-аар (21.2%) нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

### ЕРДИЙН ЦЭВЭР ӨСӨЛТ, *сүүлийн 5 жилийн эхний 6 сард*

4.6 — Хамгийн бага

Хамгийн их — 8.2

*Ердийн цэвэр өсөлт*: **Хүн амын тооны өсөлт, бууралтыг харуулна.**

## ТӨРСӨН ХҮҮХЭД

| 2021 I-VI | 2022 I-VI |
| --- | --- |
| 1242 | 1078↓ |

Дүүргийн хэмжээнд 2022 оны эхний 6 сард 1068 эх амаржиж, 1078 хүүхэд шинээр мэндэлж, 9-н амьгүй төрөлт бүртгэгдсэн байна.

Эх, хүүхдийн эндэгдлийн 16 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 5 тохиолдлоор (45.5%) нэмэгдсэн сөрөг үзүүлэлттэй байна.

### ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

- 11 — 0-1 хүртэлх насны
- 1-5 хүртэлх насны — 5↑
- - — Эхийн эндэгдэл

### ЭХИЙН ТӨРӨЛТ

- 5↑ — Гэрийн төрөлт
- Хяналтгүй төрөлт — 4↓

Өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 13.5 хувиар буурчээ. Гэрийн төрөлтийн 5, хяналтгүй төрөлтийн мөн 4 тохиолдол бүртгэгдсэн байна.

## ЭРҮҮЛ МЭНД

### НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 2021 I-VI | Халдварт өвчин | 151 | 7568 |
| | Цочмог халдварт өвчин | 7417 | |
| 2022 I-VI | Халдварт өвчин | 151 | 12702 |
| | Цочмог халдварт өвчин | 12551 | |

2022 оны эхний 6 сард 10.0 мянган хүн тутмын 878.6 нь цочмог, 10.2 нь халдварт өвчнөөр өвчилсөн байна.

### ХАЛДВАРТ ӨВЧИН - 151

- Тэмбүү 59 ↑
- Мөөгөнцөр 4 ↓
- Заг хүйтэн 37 ↑
- Сүрьеэ 44 ↓
- Трихомониаз 7

### ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН -12551

- Гепатит 4 ↑
- Сальмонелла 12 ↑
- Цусан суулга 27 ↑
- Гар, хөл, амны өвчин 20 ↑
- Ковид 12417 ↑
- Салхин цэцэг 63 ↑
- Бусад 8 ↑

Коронавирус халдварын тохиолдол оны эхний 1 сард 8765, 2 сард 2641, 3 сард 651 бүртгэгдэж, харин 4 болон 5 сард бүртгэгдээгүй зэрэг үзүүлэлттэй байсан бол 6 сард 360 тохиолдол бүртгэгдсэн сөрөг үзүүлэлттэй байна.

## НИЙГМИЙН ХАЛАМЖ



### Ehalamj системээр 2022 оны 6 сард олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийн мэдээ

| | 2022 I | 2022 VI |
|---|---|---|
| Халамжийн тэтгэвэр | 1 815 хүн<br>522.2 сая төг | 1 803 хүн<br>512.1 сая төг |
| Алдарт эх одонгийн мөнгө | 7 939 хүн<br>971 сая төг | 445 хүн<br>44.5 сая төг |
| Алдар цолтон ахмад настан хөнгөлөлт | 5 хүн<br>1.2 сая төг | 12 хүн<br>3.1 сая төг |
| Хүүхдийн мөнгөн тэтгэмж | 51 525 хүн<br>5 152.5 сая төг | 51 901 хүн<br>5 190.1 сая төг |
| Бусад тэтгэмж | 17 516 хүн<br>1 340.9 сая төг | 20 457 хүн<br>1701.2 сая төг |

## НИЙГМИЙН ДААТГАЛ

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН

| | 2021 I-VI | 2022 I-VI |
|---|---|---|
| ОРЛОГО, тэрбум төгрөг | 169.5 | 214.1 ↑ |
| ЗАРЛАГА, тэрбум төгрөг | 72.5 | 87.5 ↑ |

### ОЛГОСОН ТЭТГЭВЭР

| | 2021 I-VI | 2022 I-VI |
|---|---|---|
| Тэтгэвэр авагчийн тоо, мянган хүн | 20.1 | 21.1 ↑ |
| Олгосон тэтгэвэр, тэрбум төгрөг | 57.5 | 73.3 ↑ |

### ОЛГОСОН ТЭТГЭМЖ

| | 2021 I-VI | 2022 I-VI |
|---|---|---|
| Хамрагдсан хүн, мянган хүн | 11.9 | 17.5 ↑ |
| Олгосон тэтгэмж, тэрбум төгрөг | 15.0 | 14.3 ↓ |

## БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

**2021 I-VI 534** | **2022 I-VI 602** ↑

### БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, *насны ангиллаар, дунд эзлэх хувиар*, 2022 I-VI

| Насны ангилал | Нийт | Хувь | | |
|---|---|---|---|---|
| 15-24 насны | 40 | (6.6%) | 23 | 17 |
| 25-34 насны | 221 | (36.7%) | 109 | 112 |
| 35-44 насны | 203 | (33.7%) | 94 | 109 |
| 45-54 насны | 99 | (16.5%) | 38 | 61 |
| 55-59 насны | 28 | (4.7%) | 16 | 12 |
| 60+ насны | 11 | (1.8%) | 8 | 3 |

Дүүргийн ХХҮХ-т бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 6 сарын эцэст 602 болж, өмнөх оны мөн үеэс 68-аар (12.7%) өссөн үзүүлэлттэй байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдээс оны эхний 6 сард 372 иргэн ажилд зуучлагдан орсон нь өмнөх сараас 213 буюу 159-өөр (74.6%) нэмэгджээ.

## БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

**2021 I-VI** 940 | **2022 I-VI** 1836 ↑

| 1-р хэлтэс | 2-р хэлтэс |
|---|---|
| (1-9 дүгээр хороо) | (10-20 дугаар хороо) |
| Бүртгэгдсэн гэмт хэрэг 1187 (64.6%) | Бүртгэгдсэн гэмт хэрэг 649 (35.4%) |
| Илрүүлэлт 41.2% | Илрүүлэлт 48.7% |



Дүүргийн хэмжээнд 2022 оны эхний 6 сард 1-р хэлтэст 1187, 2-р хэлтэст 649, нийт 1836 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеийнхээс 896 хэргээр 2.0 дахин өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн илрүүлэлт дүүргийн хэмжээнд 44.1 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 9.0 нэгж хувиар нэмэгджээ.

Мөн зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 9217 бүртгэгдсэн байна.

## БҮРТГЭГДСЭН ТҮЙМЭР, ҮЕР, УС

### БҮРТГЭГДСЭН ГАЛ ТҮЙМЭР, *төрлөөр*

| | 2021 I-VI | 2022 I-VI |
|---|---|---|
| Обьектын | 65 | 88 ↑ |
| Хогны | 5 | 16 ↑ |
| Өнжмөл шар өвсний | 5 | 65 ↑ |

### БҮРТГЭГДСЭН ҮЕР, УСНЫ ДУУДЛАГА

| | 2021 I-VI | 2022 I-VI |
|---|---|---|
| Үер ус, халиа дошин | 16 | 1 ↓ |

2022 оны эхний 6 сард дүүргийн хэмжээнд объектын гал түймрийн 88, хогны 16, өнжмөл шар өвс шатсан 65, халиа дошны 1, нийт 170 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 79-өөр буюу 1.9 дахин нэмэгдсэн сөрөг үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн гал түймрийн өсөлтөд өнжмөл шар өвс шатсан дуудлага 60-аар буюу 13.0 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

## ДҮҮРГИЙН ТӨСӨВ

### ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО, *сая төгрөг*

- Төлөвлөгөө 150 107.2
- Гүйцэтгэл 127 232.1
- *Биелэлт 84.8%*

2022 оны эхний 6 сард дүүргийн төсөвт 127.2 тэрбум төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 84.8 хувиар биелжээ. Төвлөрсөн орлогын 95.3 хувийг урсгал орлого, 4.7 хувийг төсвийн урсгал санхүүжилтийн орлого эзэлж байна.

Харин урсгал орлогын 99.2 хувийг татварын орлого, 0.8 хувийг татварын бус орлого бүрдүүлжээ.

### ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА, *сая төгрөг*

- Төлөвлөгөө 147 908.7
- Гүйцэтгэл 125 721.1
- *Биелэлт 85.0%*

Оны эхний 6 сарын байдлаар төвлөрсөн орлогын 98.8% буюу 125.7 тэрбум төгрөг урсгал зардалд зарцуулаад байна.

Урсгал зардлын дийлэнх буюу 99.6%-ийг бараа үйлчилгээний, 0.4%-ийг бусад зардал эзэлж байна.

## АЖ ҮЙЛДВЭР *(*урьдчилсан гүйцэтгэл)*

| | | | |
|---|---|---|---|
| 2021 I-VI | Нийт үйлдвэрлэл | 1 822.7 | тэрбум |
| | Нийт борлуулалт | 3 399.6 | төгрөг |
| 2022 I-VI | Нийт үйлдвэрлэл | 1 595.2*↓ | тэрбум |
| | Нийт борлуулалт | 3 009.0*↓ | төгрөг |

### АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар

| | 2021 I-VI | 2022 I-VI |
|---|---|---|
| УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ (7.3%↑) | 1 390.0 *тэрбум төгрөг* | 1 491.4*↓ *тэрбум төгрөг* |
| БОЛОВСРУУЛАХ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ (76.1%↓) | 430.6 *тэрбум төгрөг* | 103.1*↓ *тэрбум төгрөг* |
| ЦАХИЛГААН, ДУЛААН, ЭРЧИМ ХҮЧ, УСАН ХАНГАМЖ ҮЙЛДВЭРЛЭЛ (66.7%↓) | 2.1 *тэрбум төгрөг* | 0.7*↓ *тэрбум төгрөг* |

## ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

Цэвэрлэсэн зам талбай 436.8 *мян.м2*

Зарцуулсан хөрөнгө 1 437.7 *сая төгрөг*

### ТЭЭВЭРЛЭСЭН ХОГ, *байршлаар*, 2022 I-VI

- 18 108.0↑ тн — Орон сууцнаас
- Гэр хорооллоос — 11 081.0↑ тн
- 5 857.6↓ тн — Зуслангаас

2022 оны эхний 6 сард дүүргийн хэмжээнд 35.0 мянган тонн хог тээвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 7.7 мянган тонноор буюу 28.0 хувиар өсжээ.

Тээвэрлэсэн хогны 51.7 хувийг орон сууцнаас, 31.6 хувийг гэр хорооллоос, 16.7 хувийг зуслангаас тус тус тээвэрлэжээ.

Хог тээвэрлэлтэд нийт 1437.7 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 359.1 сая төгрөгөөр (25.0%) өссөн үзүүлэлттэй байна.

ТООЛЛОГО
ХӨДӨӨ АЖ АХУЙ 2022

2022 ОНЫ 6 ДУГААР САРЫН 17-НООС 30 ХҮРТЭЛ

## ХӨДӨӨ АЖ АХУЙН 2022 ОНЫ УЛСЫН ЭЭЛЖИТ ТООЛЛОГО СҮХБААТАР ДҮҮРЭГТ АМЖИЛТТАЙ ЯВАГДАЖ ДУУСЛАА

ТООЛЛОГОДОО ИДЭВХТЭЙ ХАМРАГДСАН ДҮҮРГИЙН ХАА-Н САЛБАРТ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧ ААНБ, ИРГЭН ТАНД ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЬЕ



СҮХБААТАР ДҮҮРГИЙН ТООЛЛОГЫН КОМИСС